

[ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР]

Огноо: 2020.02.21

[ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭХ ШАТАХУУН ХУДАЛДАН АВАХ]
БАРАА НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ
АВАХ БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Төрийн үйлчилгээнд хэрэглэх шатахуун худалдан авах

Төслийн дугаар: 202002014

Харьцуулалт/ гэрээний
дугаар: ХА-02

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Даланжаргалан сумын ЗДТГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос [Төрийн үйлчилгээнд хэрэглэх шатахуун]-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг [2020 оны 3 дугаар сарын 09-ны 10 цаг]-аас өмнө [<https://www.tender.gov.mn/>] хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан [2020 оны 3 дугаар сарын 09]-ны өдрийн [10 цаг 40 минутад] -т нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Даланжргалан сумын ЗДТГ
ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Оюунбямба, Утас:86046644

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өтгөдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.

Тендер ирүүлэх,
тендерийн нээлт

Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягуудыг нууцлахгүй ирүүлнэ.

Тендерийн
бүрдэл

иж

Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

- Үнийн санал;
- Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
- Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
- Хуулийн этгээдийн улсын бүртгэл / Иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар
- Тендерт оролцогчийг төлөөлөх этгээдийн итгэмжлэл
- Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар / Нотриатаар баттуулсан ./
- Шатахуун түгээх станцын техникийн дүгнэлт
- Галын аюулгүй байдлын дүгнэлт
- Татварын хэлтсийн тодорхойлолт/ Хэвлэсэн Е баримтын хуулбар /
- Харилцагч банкны тодорхойлолт / Өргүй байх /
- Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт / Өргүй байх /
- Үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл сууринуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын саналыг авсан байх
- Газрын гэрчилгээний хуулбар
- Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ

Нэмэлт тодруулга: Тодорхойлолтуудыг ТББ цахимд тавигдсанаас хойш авсан байх

Тогтмол үнэ

Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол

| | | |
|---|---|--|
| | | байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| Техникийн тодорхойлолт арилжааны нөхцөлүүд ба | | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | | Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. |
| | | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| | | Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав. ТЕНДЕР шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт

| ТӨӨЗ-НЫ ХОЛБОГДОХ ЗААЛТ | ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ |
|-------------------------------|--|
| ТОӨЗ 1.1 | <p>Сүүлийн [2] жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/;</p> <p>Сүүлийн [2] туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <ul style="list-style-type: none"> • Хуулийн этгээдийн улсын бүртгэл / Иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар • Тендерт оролцогчийг төлөөлөх этгээдийн итгэмжлэл • Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар / Нотриатаар батлуулсан / • Шатахуун түгээх станцын техникийн дүгнэлт • Галын аюулгүй байдлын дүгнэлт • Татварын хэлтсийн тодорхойлолт/ Хэвлэсэн Е баримтын хуулбар / • Харилцагч банкны тодорхойлолт / Өргүй байх / • Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт / Өргүй байх / • Үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын саналыг авсан байх • Газрын гэрчилгээний хуулбар • Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.</p> <p>Үүнд: Аж ахуйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл</p> |
| ТОӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: [Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем]</p> <p>Давхар болон өрөөний дугаар:</p> <p>https://www.tender.gov.mn/</p> <p>Огноо: [2020.03.09]</p> <p>Цаг: [10 цаг 00 минутаас өмнө]</p> |
| ТОӨЗ 2.1 | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: [Даланжаргалан сумын ЗДТГ-ын дэргэдэх иргэний танхим]</p> <p>Давхар болон өрөөний дугаар: ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Соёл-Ундрях, Утас -94777007</p> <p>Огноо: [2020 оны 3 дугаар сарын 09-ны өдөр]</p> <p>Цаг: [10 цаг 40 минут]</p> |
| ТОӨЗ 2.3 | <p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Үнийн санал; • Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь; • Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг; • Хуулийн этгээдийн улсын бүртгэл / Иргэн бол иргэний |

| | |
|--|--|
| | <p>үнэмлэхний хуулбар</p> <ul style="list-style-type: none"> • Тендерт оролцогчийг төлөөлөх этгээдийн итгэмжлэл • Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар / Нотриатаар батлуулсан ./ • Шатахуун түгээх станцын техникийн дүгнэлт • Галын аюулгүй байдлын дүгнэлт • Татварын хэлтсийн тодорхойлолт/ Хэвлэсэн Е баримтын хуулбар / • Харилцагч банкны тодорхойлолт / Өргүй байх / • Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт / Өргүй байх / • Үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл сууринтуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын саналыг авсан байх • Газрын гэрчилгээний хуулбар • Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ <p>Нэмэлт тодруулга: Тодорхойлолтуудыг ТББ цахимд тавигдсанаас хойш авсан байх</p> |
|--|--|

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
БАРААНЫ ТОДОРХОЙЛОЛТ:

Нийлүүлэх шатахуун нь Монгол улсын MNS 0216 : 2017, MNS 0217 : 2017 стандартын шаардлагыг хангасан байх.

Тендерийн шалгаруулалтанд оролцож байгаа байгууллагын шатахуун түгээх станц нь “Шатахуун түгээх станц Техникийн шаардлага MNS 4628-2013 Монгол Улсын стандартын шаардлага хангасан байх.

Нийлүүлэгч байгууллага нь шатахуун, шатах тослох материалын “Итгэмжлэгдсэн лаборатори”-той байх ба бүтээгдэхүүнүүд нь зохих хугацаанд шинжилгээнд хамрагдаж баталгаажсан байх.

Шатахуун түгээгүүрийн газар нь 24 цагийн үйлчилгээтэй байх.

Монгол Улсын стандарт:

MNS 0216 : 2017. Дизелийн түлш Евро.Техникийн шаардлага;

MNS 0217 : 2017. Хөдөлгүүрийн түлш. Этилжуулээгүй бензин.

Бараа хүргэх газар: [Даланжаргалан сумын ЗДТГ, ЭМТ]

Бараа нийлүүлэлтийн хуваарь: Гэрээ байгуулсанаас хойш 12 сарын хугацаанд

Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь:

| Д/д | Төрөл | Тоо ширэг /Хэмжих нэгж л/ | ТШӨХ-Д хүргэх эцсийн цэг | Заасан барааг | Стандарт чанарын шаардлага | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|-----|-------|------------------------------|-----------------------------------|------------------|--|---|------------|---|
| | | | | | | 6 | 7 | 8 |
| 1 | A-80 | 100 | Даланжаргалан сумын ЗДТГ, ЭМТ | | Октаны тоо: Хөдөлгүүрийн аргаар – 76аас дээш Шинжилгээний аргаар - 80 | 2020.01.01 | 2020.12.31 | |
| | | | | | Буцалж нэр эхлэх темпратур – 35 ⁰ C | | | |
| | | | | | Нэрэгдэх темпратур С 10%-аас ихгүй – 75 50%-аас ихгүй – 120 90%-аас ихгүй - 190 | | | |
| | | | | | Нэрэгдэж дуусах үеийн темпратур - 215 ⁰ C ихгүй | | | |
| | | | | | Ханасан уурын даралт мг КОН 100см ³ бензинд 35-70 байх | | | |
| | | | | | Бодит давирхай мг 100см ³ бензинд ихгүй байх хэмжээ -3 | | | |
| | | | | | Хүхрийн хэмжээ 5%-аас ихгүй | | | |
| | | | | | Усанд уусах хүчил шүлтийн хэмжээ- 0,05 | | | |
| | | | | | Механик хольц / ус – Байхгүй | | | |
| | | | | | Зэс хавтгайн туршилт-Даана | | | |
| 2 | A-92 | 8363 | | | Шинжилгээний аргаар -85аас дээш | | | |
| | | | | | Этилийн шингэн 1кг-д - 0,82 гр | | | |

| | | | | | | | |
|---|-----------------|----|--|--|--|--|--|
| | | | | Бүтэц нэрж эхлэх темпратур С Зуны бензин -35 Өвлийн бензин 10% бензиний буцлах темпратур Зуны бензин -70 Өвлийн бензин-55 10% бензиний буцлах темпратур Зуны бензин -35 Өвлийн бензин 50% бензиний буцлах темпратур Зуны бензин -115 Өвлийн бензин-100 90% бензиний буцлах темпратур Зуны бензин -180 Өвлийн бензин-160 Буцах эцсийн темпратур Зуны бензин -195 Өвлийн бензин-185 Ханасан уурын даралт мөнгөн усны баганаар /мм-зэр / Зуны бензин -200 Өвлийн бензин-500-700 Хүхрийн хэмжээ 0,1 % / дээш бус / Давирхайн хэмжээ 7 мг м/л /дээш бус / Цетаны тоо / Бага бус / 45 Өтгөн шингэн чанар /Кинемитак 20С сет бүтэц /: 3,5-8,0 10% буцлах темпратур 50% буцлах темпратур-290 90% буцлах темпратур-350 98% буцлах темпратур Асах температур -60 Цацрах температур - /-10/ Хүхрийн хэмжээ %-иар /дээш бус /-0,2 Хувийн жин -1,13 Буцалж эхлэх температур С-216 Кинематик зунгалаг 100с—т - 2,26 Ph -9.86 | | | |
| 3 | Дизель | 50 | | | | | |
| 4 | Тосол, масло | 20 | | | | | |

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.

| Д/д | Төрөл | Тоо ширхэг /Хэмжих нэгж/ | Үнэ / 1 литр / | Стандарт чанарын шаардлага | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|-----|-------------|--------------------------|----------------|----------------------------|---|--------------------------|---|
| | | | | | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэх эцсийн санал болгосон хугацаа |
| 1 | 2 | 3 | | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | A80 | | | | | | |
| 2 | A92 | | | | | | |
| 3 | Дизель тулш | | | | | | |
| 4 | Мало, тос | | | | | | |

Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.

Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. Нэгдсэн хүснэгт: өмнө болон Одоо хэрэгжиж буй гэрээ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|--------------|--|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

| | |
|---|--|
| Шалгах болон турших | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| Оюуны өмчийн эрх | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| Баталгаат засварын хугацаа | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна. |
| Гэрээнд өөрчлөлт оруулах | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| Төлбөр | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| Бараа нийлүүлэх хуваарь | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| Алданги оногдуулах | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| Маргааныг шийдвэрлэх | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Шалгах болон [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх турших
(ГЕН – 1) шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]

Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

Баталгаат засвар (ГЕН-5) Баталгаат засварын тусгай шаардлага.

[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]

Төлбөр (ГЕН – 7) Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
Гэрээний үнийн дүнгийн [100] хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.

Алданги оногдуулах (ГЕН - 9) Алданги оногдуулах хувь: [10]
Алдангийн нийт дүн: [0,5]

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны _____ дугаар сарын _____-наас _____ оны _____ дугаар сарын _____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг¹;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;

¹ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийн д.

Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]